

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ**

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

ДУУССАН АЖЛЫН ТАЙЛАН

Сэдвийн нэр: Бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийг илрүүлэх,
оношлох

Дэд сэдвийн удирдагч: П.Жамъян, АУ-ы доктор, Анагаахын удамзүйн
лабораторийн эмч

Дэд сэдвийн зөвлөх: Д.Энэбиш, АУ-ы доктор, Профессор, АШУҮИС-ийн
Эмзүй, Био-Анагаахын сургуулийн Биохими-
Лабораторийн тэнхимийн багш

Гүйцэтгэгчид: Р.Батсолонго, АУ-ы магистр, Хүүхдийн эрчимт
эмчилгээний тасгийн эрхлэгч
Ч.Наранцэцэг, АШУ-ы магистр, Нярайн эрчимт
эмчилгээний тасгийн эрхлэгч
О.Энхчимэг, АУ-ы магистр, Мэдрэлийн эмгэг судлалын
тасгийн эрхлэгч
Б.Болормаа, АУ-ы магистр, Мэдрэлийн эмч

**Бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийг
эрсдэлтэй бүлэгт илрүүлэх, оношлох
(Монгол хураангуй)**

Удирдтгал: Бодисын солилцооны төрөлхийн эмгэг гэдэг нь нэг генийн мутаци өөрчлөлтөөс үүдэн бодисын солилцооны замд эмнэлзүйн холбогдол бүхий саатал үүсдэг ховор тохиолдох удамшлын өвчин юм. Эмнэлзүйн шинж тэмдэг нь субстрат бие махбодод хуримтлагдсанаас хэвийн үйл ажиллагааг саатуулж, хордлого үүсгэснээс эсвэл амин чухал бодисуудын нийлэгшилд оролцох бодисуудын дутмагшлаас үүсдэг. Манай улсад бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн лаборатори, генетикийн шинжилгээгээр батлагдсан тохиолдол одоогоор бүртгэгдээгүй байна.

Судалгааны зорилго: Органик ба амин хүчлийн солилцооны төрөлхийн эмгэгийг илрүүлж, оношлох

Судалгааны зорилт:

1. Хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээг эрсдэлтэй бүлэгт хийн органик ба амин хүчлийн солилцооны төрөлхийн эмгэгийг илрүүлэх
2. Хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээгээр оношлогдсон тохиолдлуудад мутаци илрүүлэх шинжилгээ хийж оношийг баталгаажуулах

Аргачлал: Эмнэлзүйд шалтгаан тодорхойгүй сэтгэц, хөдөлгөөн, биеийн хөгжлийн хоцрогдол, таталт, гипотони, элэгний үйл ажиллагааны өөрчлөлттэй 223 хүүхдийг судалгаанд хамруулсан. Бүх өвчтөний шээсэнд хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээгээр органик хүчлийн харьцаа, хэмжээг тодорхойлсон ба шээсний шинжилгээнд өөрчлөлттэй тохиолдолд цусанд амин хүчил, ацилкарнитины түвшинг тодорхойлсон. Масс спектрометрийн шинжилгээнд бодисын солилцооны төрөлхийн эмгэг оношлогдсон тохиолдолд мутаци илрүүлэх шинжилгээг хийсэн.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан өвчтөнүүдээс 139-д нь шээсний органик хүчлийн шинжилгээнд ямар нэг эмгэг өөрчлөлт илрээгүй ба 31-д нь

вальпроатын хүчлийн завсрын бүтээгдэхүүнүүд, 17-д нь кетозгүй, дикарбоксилын хүчлүүд, 14-д нь тирозилури, 12-д нь кетоз, 4-д нь лактат, пируват ихэссэн, 3-д нь глицерол, метилмалонат ихэссэн, 2-д нь фенилацетат ба фениллактат ихэссэн ба фенилацетат ба фениллактат ихэссэн нь Фенилкетонури өвчнийг зааж байсан. Шээсний органик хүчлийн шинжилгээнд өөрчлөлттэй 38 өвчтөнд цусны амин хүчил ба ацилкарнитиныг тодорхойлсноос 2 өвчтөнд фенилаланин ихэссэн нь шээсний шинжилгээтэй дүйж байна. Төрөлхийн цитрин дутагдал 1 өвчтөнд сэжиглэгдсэн. Масс спектрометрийн шинжилгээгээр Фенилкетонури оношлогдсон 2 өвчтөнд *PAH* генд мутаци илрүүлэх шинжилгээ хийсэн ба p.R243Q, p.Y356X, p.V399V, p.A403V мутациуд илэрсэн. Фенилкетонури илэрсэн 2 өвчтөн хоёул сэтгэц, хөдөлгөөний хоцрогдолтой шалтгаанаар шинжилгээнд хамрагдсан байсан.

Дүгнэлт: Эдгээр нь масс спектрометрийн шинжилгээ ба мутаци илрүүлэх шинжилгээгээр онош батлагдсан фенилкетонури өвчний Монгол дах анхны тохиолдол ба өндөр эрсдэлтэй бүлэгт хийгдсэн илрүүлэг шинжилгээгээр фенилкетонури өвчин 1/112 байна. Шинжилгээгээр илэрсэн 2 тохиолдол хоёулаа сэтгэцийн хоцрогдолд хэдийн хүрсэн байгаа нь уг өвчнийг тархины эргэшгүй өөрчлөлт, сэтгэцийн хоцрогдолд хүргэхээс өмнө эрт хугацаанд илрүүлж, өвчтөнийг дэглэм ба эмийн эмчилгээнд хамруулах шаардлагатайг харуулж байна.

Results of selective screening of inborn errors of metabolism in Mongolia

Background: Inborn errors of metabolism (IEM) are rare genetic disorders in which a single gene defect causes a clinically significant block in a metabolic pathway. Clinical problems arise due to either accumulation of substrates that are toxic or interfere with normal function, or deficiency of the products that are used to synthesize essential compounds. There is no report of screening results or confirmed cases of IEM in Mongolia. Only pilot study of newborn screening for congenital hypothyroidism was implemented in Mongolia, where the incidence of congenital hypothyroidism is calculated to be 1:3057 in Mongolia.

Goal: To determine the organic acidemias and aminoacidopathias in Mongolia

Aims:

1. To detect the organic acidemias and aminoacidopathias in high risk group using gas chromatography mass spectrometry
2. To confirm the diagnosis of the patients using molecular genetic analysis

Methods: Two hundred twenty-three Mongolian patients, who had developmental delay, psychomotor retardation with unknown cause, seizures, hypotonia or liver dysfunction, were studied. Urinary organic acid analysis was performed in all cases using gas chromatography mass spectrometric (GC/MS) analysis. Blood amino acids and acylcarnitines were checked in the patients who had abnormal GC/MS analyses. Mutation analysis was done in the patients, who were suspected having specific inborn errors of metabolism by mass spectrometric analysis.

Results: One hundred thirty-nine children had normal urinary organic acid analyses. Thirty one had metabolites of valproic acid, 17 had non- or hypoketotic dicarboxylic aciduria, 14 had tyrosiluria, 12 had ketosis, 4 had elevation of lactate and pyruvate, 3 had increased excretion of urinary glycerol or methylmalonic acids, respectively, and 2 had elevation of phenylacetate and phenyllactate. We checked blood amino acids and acylcarnitines in 38

patients, which revealed phenylketonuria (PKU) in 2 patients, and one with suspected citrin deficiency. Mutation analysis in *PAH* was done in 2 patients with PKU, and previously reported p.R243Q, p.Y356X, p.V399V, p.A403V mutations were detected.

Discussion:In conclusion, these were the first genetically confirmed cases of PKU in Mongolia, and the study suggested that the newborn screening program for PKU was significant because it enabled early treatment dietary restriction, specialized formulas and other medical management for prevention of neurological handicaps in these children.

Дэд сэдвийн нэр: Бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийг илрүүлэх, оношлох

Төслийг санхүүжүүлэгч: Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч: ЭМЯ

Хугацаа: 2013-2016 он

Дэд сэдвийн удирдагч: П.Жамъян, АУ-ы доктор, Анагаахын удамзүйн лабораторийн эмч

Дэд сэдвийн зөвлөх: Д.Энэбиш, АУ-ы доктор, Профессор, АШУҮИС-ийн Эмзүй, Био-Анагаахын сургуулийн Биохими-Лабораторийн тэнхимийн багш

Гүйцэтгэгчид: Р.Батсолонго, АУ-ы магистр, Хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч
Ч.Наранцэцэг, АШУ-ы магистр, Нярайн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч
О.Энхчимэг, АУ-ы магистр, Мэдрэлийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч
Б.Болормаа, АУ-ы магистр, Мэдрэлийн эмч

Дэд сэдвийн үр дүнгийн даалгавар:

1. Бодисын солилцооны буюу органик хүчлийн солилцооны эмгэгийн зонхилох хэлбэрүүд, давтамжийг тодорхойлсон үр дүн - Эрдэм шинжилгээний өгүүлэл
2. Бодисын солилцооны төрөлхийн эмгэгийг масс спектрометрийн шинжилгээний аргаар илрүүлэх оношилгооны удирдамж

Төслийн үр дүнгийн даалгавар 1-ийн хүрээнд Америкийн “Molecular Genetics and Metabolism Reports” сэтгүүлд “The first Mongolian cases of phenylketonuria in selective screening of inborn errors of metabolism” сэдэвт өгүүлийг хэвлүүлж (Хавсралт 1) www.ncbi.nlm.nih.gov www.sciencedirect.com-д цахим хэлбэрээр байршуулсан.

1. Purevsuren J, Bolormaa B, Narantsetseg C, Batsolongo R, Enkhchimeg O, Munkhuu B, Hasegawa Y, Shintaku H, Seiji Yamaguchi. The first Mongolian cases of phenylketonuria in selective screening of inborn errors of metabolism. *Mol Genet Metab Rep.* 2016 Oct 28;9:71-74. PMID:7830119
2. Д.Энэбиш, П.Жамьян. Фенилаланин, тирозины солилцооны төрөлхийн алдагдал, оношилгоо. (Хэвлэлийн тойм) Эх барих эмэгтэйчүүд, хүүхэд судлал, 2015.02 (18). 1232-1236.

Хэвлэлийн тойм

Монгол улсын мянганы хөгжлийн зорилтуудад “Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2015 он гэхэд 1990 онтой харьцуулахад 4 дахин бууруулах”-аар заасан ба НҮБ-ийн хүүхдийн сангийн мэдээнээс үзвэл үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлснээр 1990 оныг 2010 онтой харьцуулахад 5 хүртэлх насны хүүхдийн нас баралт 1000 амьд төрөлтөнд 107-гоос 32 болж 3.3 дахин буурчээ [1]. Хэдийгээр хүүхдийн эндэгдэл буурч байгаа ч хөгжсөн орнуудтай харьцуулахад өндөр байна. Үүний шалтгаанд бодисын солилцооны төрөлхийн эмгэгүүд тодорхой байр эзэлж байгааг үгүйсгэхгүй. Бодисын солилцооны төрөлхийн эмгэгүүдийг эрт илрүүлж, зөв оношилж, эмчилгээний зохистой удирдамж гаргах нь манай оронд тохиолдож байгаа нялхас, хүүхдийн эндэгдлийг тодорхой хувиар бууруулах, эмгэгээс үүсэж болох хожуу үеийн үлдэц, хөгжлийн бэрхшээлээс сэргийлэх ач холбогдолтой тулгамдсан асуудал юм.

Бодисын солилцооны төрөлхийн эмгэг нь бие махбод дахь чухал үүрэг бүхий ферментийг хариуцсан ихэвчлэн нэг гений гажгаар үүсгэгддэг эмгэг. Энэ эмгэгийн үедбие махбодод бодисын солилцооны завсрын хорт бодис ихээр хуримтлагдсанаас эсвэл бие махбодод чухал хэрэгцээтэй бодисууд дутагдсанаас эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрдэг. Өвчний нийт тохиолдол улс орон бүрт харилцан адилгүй байдаг ба азийн орнуудад хийгдсэн судалгаагаар нийт амьд төрөлтөнд тохиолдох тоо 1:2000-9000 байна. Эх барихын үеийн гэмтэл, төрөлхийн хөгжлийн гажиг, хромосомын эмгэг гэх мэт мэдэгдэхүйц шалтгаангүйгээр өсөлт хөгжлийн доройтол, хоцрогдол, оюунухааны хомсдол, энцефалопати, уналт, таталт, цохиулалт, зүрхний ба бусад төрлийн булчингийн эмгэг, элэг дэлүү томролт, давтан бөөлжилт, бодисын солилцооны хүчилшил, цусан дахь чихрийн багасалт, аммон, кетон биеийн ихсэлт гэх мэт эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн сэжигтэй буюу өндөр эрсдэлтэй бүлэгт хийгдсэн Азийн орнуудын судалгаагаар эдгээр бүлэг өвчнүүд Вьетнамд 1:11, Энэтхэгт 1:19, Хятадад 1:54, Японд 1:66 тохиолдсон байна [2-11]. Үүнд фенилкетонури, лейциноз (MSUD), гомоцистинури гэх мэт амин хүчлийн солилцооны эмгэгүүд, метилмалонат ацидеми, пропионат ацидеми, 1-р

хэлбэрийн глутарат ацидеми гэх мэт органик хүчлийн солилцооны эмгэгүүд зонхилон тохиолдсон байна. Хөгжсөн орнуудад эдгээр эмгэгийг оролцуулаад нийт 20 гаруй нэр төрлийн органик, амин хүчлийн солилцооны эмгэгүүдийг масс спектрометрийн шинжилгээгээр шээсэндэх органик хүчлийг тодорхойлон илрүүлж байгаа ба энэ нь нэг сорьцноос, нэг шинжилгээний аргаар бодисын солилцооны олон нэр төрлийн эмгэгийг оношлох боломж бүхий инвазив бус арга юм. Одоогийн байдлаар Монголд эмнэлзүйн хувьд органик, амин хүчлийн солилцооны эмгэгийн сэжигтэй тохиолдол илэрч байгаа боловч үйл ажиллагаа, удамзүйн шинжилгээгээр оношлогдсон тохиолдол үгүй, энэ талын судалгаа шинжилгээ ховор байна. Н.Мөнхтүвшин нарын фенилкетонурийг илрүүлэх зорилгоор оюун ухааны хомсдолтой 620 өвчтөнд Гутрийн аргаар фенилаланины түвшинг тодорхойлсон судалгаагаар 10 өвчтөнд (1.63%) [12] хэвийн хэмжээнээс өндөр гарсан ба гадаадын судлаачдынхаас 2 дахин өндөр байгаа нь үүнийг нарийвчлан судалж, оношийг батлах шаардлагатайг харуулж байна. Бамбай булчирхайн төрөлхийн дутагдал Монгол улсад 1:3057 байна [13, 14]. Эдгээр өвчнийг эрт оношилсноор дэглэм барих, бодисын солилцооны оврого үүсэж болох нөхцөл байдлын үед урьдчилан сэргийлэх эмчилгээний удирдамж гаргаснаар түүнээс үүдэж болох хөгжлийн бэрхшээлүүдээс сэргийлэх боломжтой. Бодисын солилцооны төрөлхийн эмгэг нь эрт үед оношлогдож эмчлэгдээгүй тохиолдолд хөгжлийн бэрхшээлд хүргэдгээс хүүхдийн амьдралын чанарыг бууруулж, гэр бүлийн хувьд сэтгэлзүйн ба эдийн засгийн дарамтанд хүргэдэг нийгмийн тулгамдсан асуудал юм.

Судалгааны зорилго: Органик ба амин хүчлийн солилцооны төрөлхийн эмгэгийг илрүүлж, оношлох

Судалгааны зорилт:

1. Хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээг эрсдэлтэй бүлэгт хийн органик ба амин хүчлийн солилцооны төрөлхийн эмгэгийг илрүүлэх

2. Хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээгээр оношлогдсон тохиолдлуудад мутаци илрүүлэх шинжилгээ хийж оношийг баталгаажуулах

Судалгааны шинэлэг буюу дэвшилттэй тал

1. Аминхүчил ба органик хүчлийн солилцооны эмгэгийг оношлох дэвшилтэт аргыг өөрийн орны нөхцөлд анх удаа эмнэлзүйн практикт нэвтрүүлсэн.
2. Аминхүчил ба органик хүчлийн солилцооны эмгэгийг оношилдог болсноор эмчилгээний арга барилд дэвшил гарна.

Судалгааны эдийн засаг, шинжлэх ухаан, нийгмийн ач холбогдол

Өнөөгийн нөхцөлд оношилж, шалтгааныг тодруулж чадахгүй байгаа хүүхдийн бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийг дэвшилтэт аргаар оношилж, эмчлэх боломжтой болсноор гарах хүндрэлийг бууруулан, урьдчилан сэргийлэлтийн асуудлыг боловсронгуй болгож, улмаар хүүхдийн эндэгдлийг бодитойгоор бууруулах ач холбогдолтой.

Сэдрэлээс урьдчилан сэргийлэх боломжтой бодисын солилцооны төрөлхийн эмгэгийг эрт оношилж, эмчилгээний удирдамж гаргаснаар эмгэгийн хүндрэлийн улмаас хүүхэд оюун ухааны хомсдол, хөгжлийн бэрхшээлтэй болж амьдралын чанар буурахаас сэргийлнэ.

Судалгааны материал арга зүй

Судалгааны объект

Судалгаа нь нэг агшны аргаар хийгдсэн. Судалгааны түүвэрт Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн (ЭХЭМҮТ) Хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг (ХЭЭТ), Нярайн эрчимт эмчилгээний тасаг (НЭЭТ), Мэдрэлийн эмгэг судлалын тасагт (МЭСТ) 2014 – 2016 онд хэвтэж эмчлэгдэж байсанбиеийн хөгжлийн хоцрогдол, сэтгэц хөдөлгөөний хоцрогдол, таталт, гипотони зэрэг Хавсралт 1 дэх асуумж, эмнэлзүй, лабораторийн үзүүлэлтэд өөрчлөлт бүхий 1 хоногтойгоос 16 насны 223 (124 хүү, 99 охин) хүүхдийг хамруулсан. Судалгаанд хамрагдагсад дотор

цусан төрлийн гэр бүлээс төрсөн хүүхэд байгаагүй ба 19 хүүхэд гэр бүлийн асуумжтай буюу ах дүү, ойрын төрөл төрөгсөд нь ижил эмнэл зүйн шинж тэмдэг, сэтгэц хөдөлгөөний хоцрогдолтой байсан. Бүх хүүхдэд хийн хроматограф масс спектрометрийн багажаар шээсэнд органик хүчил тодорхойлох шинжилгээг хийсэн. Бодисын солилцооны эмгэгийн оношилгоо нь хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээний оношлох чадвараар хязгаарлагдсан ба зөвхөн Хавсралт 2 дахь өвчнүүд оношлогдох боломжтой байсан. Митохондрийн өөхний хүчлийн исэлдэлтийн эмгэгийг илрүүлэх, хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээгээр илэрсэн өөрчлөлтийг баталгаажуулах зорилгоор тандем масс спектрометрийн багажаар цусанд амин хүчил, ацилкарнитин тодорхойлох шинжилгээг хийсэн. Масс спектрометрийн шинжилгээгээр бодисын солилцооны төрөлхийн эмгэг оношлогдсон тохиолдлуудад мутаци илрүүлэх шинжилгээг хийсэн. Судалгаанд хамрагдсан бүх хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдаас таниулсан зөвшөөрөл авсан ба Эрүүл мэндийн яамны Анагаахын ёс зүйн хяналтын хорооноос уг судалгааг хэрэгжүүлэх зөвшөөрөл авсан.

Судалгааны арга зүй

Хийн хроматограф масс спектрометрийн багажаар шээсэнд органик хүчил тодорхойлох

Хүүхдийн шээсэн дэх 134 органик хүчлийг “Шингэнд хандлах” аргаар [15-17] цэвэршүүлж, хэмжээг ЭХЭМҮТ-ийн Анагаахын удамзүйн лабораторид АНУ-д үйлдвэрлэсэн Perkin Elmer үйлдвэрийн Clarus 680 хийн хроматограф масс спектрометрийн багажаар тодорхойлсон [15, 16]. Шинжилгээнд хэрэглэгдэх шээсний хэмжээ нь дээж тус бүрд 0.2 мг креатинин агуулж байхаар тооцоолж, органик хүчлийн концентраци нь дотоод хяналтад харьцуулсан пик талбай (relative peak area) нэгжээр хэмжигдсэн. Өдөр тутмын шинжилгээнд алкан (C10-C26)-ы холимгийг хяналтын бүлэг болгож, гептадеканы хүчил (маргарины хүчил), 3-гидрокси-2-фенилпропаны хүчил (тропикийн хүчил) ба тетракосан (C24) -ыг дотоод хяналт болгон сорьц бүрт ашигласан. Гадаад хяналтыг Япон

улсын Шиманэ их сургуулийн Масс спектрометрийн лабораторид шингээгч цаасанд шингээж хатаасан шээсийг илгээж хийсэн.

Тандем масс спектрометрийн багажаар цусанд амин хүчил, ацилкарнитин тодорхойлох

Цусанд амин хүчил, ацилкарнитин тодорхойлох шинжилгээг Япон улсын Шиманэ их сургуульд Шимадзу үйлдвэрийн LC-MSMS 8030 тандэм масс спектрометрийн багажийг ашиглан гүйцэтгэсэн. Цусны дээжийг шүүлтүүр цаасанд дусаан хатааж, хүргүүлсэн. Изотоп холбоот дотоод хяналт (Cambridge Isotope Laboratories, Kit NSK-A/B, Cambridge, UK) агуулсан метанолын 200 мкл уусмалыг 3 мм диаметр бүхий цусны дээжийг хатаасан шүүлтүүр цаасан дээр нэмж, шүүлтүүр цааснаас амин хүчил ба ацилкарнитиныг хандалж авсан. Хандалсан шингэнийг азотын хийн урсгал доор хуурайшуулж, 3N n-butanol-HCl-ын 50 мкл уусмалыг нэмж бутилжуулсаны дараа дахин хуурайшуулсан. Бутилжуулж, хуурайшуулсан дээжийг 80% ацетонитрилын уусмалд хандалсны дараа тандэм масс спектрометрийн багажаар шинжилсэн. Шинжилгээний дүнг ChemoView™ програм ашиглан тооцооллыг хийж гүйцэтгэсэн Biosystems/MDS SCIEX, Торонто, Канад) [18].


Мутац илрүүлэх шинжилгээ

Өвчтөн ба өвчтөний эцэг эхийн захын цусны цагаан эсээс QIAamp DNA Micro Kit багц цомгийг ашиглан (Qiagen GmbH, Hilden, Germany) геномын ДНХ-ийг ялган авсан. Фенилаланин гидроксилаз (PAH) гений 13 экзон тус бүрт 13 хос праймер ашиглан полимеразын гинжин урвалыг хийж гүйцэтгэсэн. Полимеразын гинжин урвалаар олшруулсан Фенилаланин гидроксилаз (PAH) гений фрагментуудын нуклеотидын дарааллыг ABI PRISM 310 Genetic Analyzer (Applied Biosystems) багаж ашиглан тодорхойлсон.

Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдагсдын эмнэл зүйн шинж тэмдгүүд нь хөгжлийн хоцрогдол 108, таталт 96, сэтгэцийн хоцрогдол 87, гипотони 81, хөгжлийн төрөлхийн гажиг 46, унтаарсан байдал 39, апнеа/диспнеа 37, элэг томорсон 34, энцефалопати 33, дахисан бөөлжилт 33, булчингийн өвдөлт 15, ком сома, кардиомиопати 10 тус тус байлаа (Зураг 1).

Зураг 1.



Шээсний органик хүчлийн шинжилгээний үр дүн: 139 хүүхдийн шээсэнд эмгэг өөрчлөлт илрээгүй ба бусад хүүхдэд дараах өөрчлөлт давхардсан байдлаар илэрсэн. Үүнд: таталтын эсрэг эм ууж байсан асуумж бүхий 31 өвчтөнд вальпроат ба түүний задралын бүтээгдэхүүн, 17 өвчтөнд кетозгүй дикарбоксилат, 14 өвчтөнд тирозилури, 12 өвчтөнд кетоз, 4 өвчтөнд лактат ба пируват, 3 өвчтөнд глицерол ба метилмалонат, 2 өвчтөнд фенилацетат ба фениллактат тус тус илэрсэн (Хүснэгт 1).

Шээсний шинжилгээнд кетозгүй дикарбоксилат, тирозилури, метилмалонат, фенилацетат, фениллактат зэрэг өөрчлөлт илэрсэн 38 өвчтөнд оношийг баталгаажуулах, митохондрийн өөхний хүчлийн солилцооны эмгэгийг үгүйсгэх зорилгоор цусанд амин хүчил, ацилкарнитиныг тодорхойлох шинжилгээ хийсэн. 2 өвчтөнд фенилкетонури өвчнийг баталсан ба тирозилури илэрсэн 1 өвчтөнд

цитруллинеми өвчнийг сэжиглэх өөрчлөлт илэрсэн. Шээсэнд метилмалонат илэрсэн өвчтөнүүдэд ацилкарнитины хэмжээ хэвийн түвшинд тодорхойлогдсон. Кетозгүй дикарбоксилат өөрчлөлт бүхий өвчтөнүүдэд митохондрийн өөхний хүчлийн солилцооны өвчин илэрсэнгүй.

Хүснэгт 1. Хийн хроматограф масс спектрометр шинжилгээний өөрчлөлт

Өөрчлөлт/эмгэг	Органик хүчлийн шинжилгээний өөрчлөлт /GCMS	Тоо	Сэжиглэх эмгэг
1 Вальпроат задралын бүтээгдэхүүн	Valproic-1, 2-Propyl-3-OH-pentanoic, 2-Propyl-3-OH-ketopentanoic, 2-Propyl-5-OH-pentanoic, 2-Propyl-hydroxyglutaric	31	Эмийн нөлөө
2 Кетозгүй дикарбоксилат ацидури	Adipic-2, Octenedioic-2, Suberic-2, Sebacic-2, Decadienedioic-2, 3-OH-octenedioic-3, 3-OH-suberic-3, 3-OH-Sebacic-3, 3-OH-dodecanedioic-3	17	Өөхний хүчлийн солилцооны эмгэг
3 Тирозилури	4-OH-phenylacetic, 4-OH-phenyllactic, 4-OH-phenylpyruvic-OX-2	14	Элэгний үйл ажиллагааны өөрчлөлт Цитрин дутагдал, Гомоцистинури
4 Кетоз	3-OH-butyric-2, Acetoacetic	12	Катаболизм
5 Лактатури	Lactic-2, Pyruvic-OX-2	4	Лактатацидеми Катаболизм
6 Метилмалонат ихэссэн	Methylmalonic-2	3	Метилмалонат ацидеми
7 Фенилкетонури	Phenylacetic-1, Phenyllactic-2	2	Фенилкетонури

Фенилкетонуритай 2 өвчтөний эмнэлзүйн өөрчлөлтийг нэгтгэн харуулбал:

Өвчтөн 1: 2 нас 9 сартай, эмэгтэй. Цусан төрлийн бус гэр бүлийн анхны хүүхэд. Жирэмсэн ба төрөлтийн явцад анхаарал татах зүйлгүй. Өвчтөн анх 9 сартайдаа таталтын улмаас харьяа эмнэлэгт хэвтэж, таталтын эсрэг депакин эмийг эмчийн заавраар ууж эхэлсэн. Хэдий тийм ч өвчтөний таталт хоорондын хугацаа ойртож, өвчин даамжирсан тул хордлогот энцефалопати оноштойгоор ЭХЭМҮТ-ийн Мэдрэлийн эмгэг

судлалын тасагт шилжиж ирсэн. Өвчтөн үе үе татах ба сэтгэц, хөдөлгөөн, хэл ярианы хоцрогдолтой байсан. Эмнэл зүйн үзлэгээр хүүхэд илэрхий гипопигментацитай ба хэдий эцэг эх нь ердийн бор арьс, хар үстэй ч өвчтөн алтлаг шар үс, цайвар цагаан арьстай байсан. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээнд эмгэг өөрчлөлт үгүй. Хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээгээр шээсэнд фенилацетат (58.4%, RPA, (хэвийн үед илрэх ёсгүй), фениллактат (261.1%, RPA, (хэвийн үед илрэх ёсгүй), фенилпируват (379.4%, RPA, (хэвийн үед илрэх ёсгүй) илэрхий ихэссэн (Хүснэгт 2). Тандем масс спектрометрийн шинжилгээгээр цусанд фенилаланин ихэссэн(1015.9 нмол/мл; хэвийн хэмжээ < 100 нмол/мл), тирозинхарьцангуй бага (44.9 нмол/мл; хэвийн хэмжээ< 250 нмол/мл), фенилаланин ба тирозины харьцаа ихэссэн (22.6; хэвийн хэмжээ<2.5) өөрчлөлт илэрсэн. Гэр бүлд *PAH* генд мутаци илрүүлэх шинжилгээ хийсэн ба өвчтөнд эцгээс дамжсан p.R243Q (с.728 G>A), эхээс дамжсан p.V399V (с.1197 A>T)мутациуд илэрсэн (Зураг 2).

Хүснэгт 2: Өвчтөн 1-ийн шээсний органик хүчлийн шинжилгээний үр дүн


ID	Органик хүчил	Үр дүн (%)	Хэвийн	хэлбэлчэл	Фактор
1	Lactic-2	2.61	(0.80	0.00 - 4.70)	3.26
10	Valproic (VPA)-1	10.14	(0.00	0.00 - 0.00)	#DIV/0!
32	Phosphoric-3	353.99	(6.60	0.00 - 43.00)	53.63
37	Phenylacetic-1	58.40	*** (0.10	0.00 - 0.40)	584.00
39	Succinic-2	16.61	(32.70	6.50 - 65.80)	0.51
42	Uracil-2	0.39	(2.80	0.00 - 7.00)	0.14
49	2-Propyl-3-OH-pentanoic-2	1.92	(0.00	0.00 - 0.00)	#DIV/0!
51	Glutaric-2	1.24	(1.90	0.00 - 4.00)	0.65
59	3-Methylglutaconic-2	0.82	(1.10	0.00 - 4.20)	0.75
63	2-Propyl-5-OH-pentanoic-2	7.09	(0.10	0.00 - 1.60)	70.90
68	Adipic-2	4.76	(3.00	0.50 - 5.00)	1.59
74	2-Propyl-hydroxyglutaric-2	14.97	(0.00	0.00 - 0.00)	#DIV/0!
83	Phenyllactic-2	261.06	*** (0.30	0.00 - 4.90)	870.20
87	2-Ketoglutaric-OX-2 (1)	76.07	(26.10	3.00 - 102.90)	2.91
88	4-OH-benzoic-2	7.49	(3.80	0.00 - 7.80)	1.97
89	4-OH-phenylacetic	106.22	(27.10	8.60 - 73.20)	3.92
90	2-Ketoglutaric-OX-2 (2)	1.82	(3.50	0.30 - 21.30)	0.52
92	Phenylpyruvic-OX-2	379.40	*** (0.00	0.00 - 0.00)	#DIV/0!
93	N-Acetylaspartic-2	1.63	(1.50	0.00 - 3.70)	1.09
100	Aconitic-3	59.54	(64.70	15.10 - 86.10)	0.92
106	Isocitric-4	38.92	(22.90	8.30 - 29.00)	1.70
107	Citric-4	1095.25	(441.10	31.40 - 572.30)	2.48
109	Hippuric-1	72.57	(30.10	6.20 - 284.10)	2.41
115	Vanilmandelic-3 (VMA)	18.47	(46.60	11.70 - 84.60)	0.40
118	4-OH-phenyllactic-2	40.65	(1.80	0.00 - 7.00)	22.58
119	4-OH-phenylpyruvic-OX-2	8.08	(0.20	0.00 - 0.90)	40.40

133	Tetracosane (C24)	30.68	(0.00	0.00	-	0.00)	#DIV/0!
134	IS-2 (tropic acid)	33.72	(0.00	0.00	-	0.00)	#DIV/0!

No . Сэжиглэх өвчин
 37 Фенилкетонури
 25 Тирозилури
 32 Вальпроат хүчил эмчилгээ

Зураг 2. Өвчтөн 1-ийн генетик шинжилгээний үр дүн

p.R243Q Arg243Gln (CGA→CAA) Сонгомол фенилкетонури



p.V399V, Val399Val (GTA>GTT) Сонгомол фенилкетонури

Өвчтөн 2: Эрүүл эхээс төрсөн, 3 нас 10 сартай, охин. Өвчтөн сэтгэц хөдөлгөөний хоцрогдол, гипотони, чихний дэлбэнгийн гаж хөгжил, артерийн цорго битүүрээгүй, зан төрхийн өөрчлөлттэй. Арьс, үсний нөсөөжилтөнд илэрхий өөрчлөлтгүй. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээнд эмгэг өөрчлөлт үгүй. Хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээгээр шээсэнд фенилацетат (6.21%, RPA, (хэвийн үед илрэх ёсгүй), фениллактат (6.19%, RPA, (хэвийн үед илрэх ёсгүй) бага зэрэг ихэссэн (Хүснэгт 3). Тандем масс спектрометрийн шинжилгээгээр цусанд фенилаланин бага зэрэг ихэссэн (654.5 нмол/мл; хэвийн хэмжээ < 100 нмол/мл), тирозин харьцангуй бага (59.6 нмол/мл; хэвийн хэмжээ < 250 нмол/мл), фенилаланин ба тирозины харьцаа ихэссэн (10.97; хэвийн хэмжээ <2.5) зэрэг өөрчлөлт илэрсэн. Өвчтөнд

РАН генд р.У356Х (с.1068 С>А) ба р.А403V (с.1208 С>Т) хавсарсан гетерозигот мутациуд илэрсэн ба эхэд хийсэн шинжилгээгээр р.А403V (с.1208 С>Т) гетерозигот мутаци тодорхойлогдсон (Зураг 3). Эцгээс нь ДНХ-ийн дээж авах боломжгүй байсан.

Хүснэгт 3: Өвчтөн 2-ын шээсний органик хүчлийн шинжилгээ


ID	Органик хүчил	Үр дүн (%)	Хэвийн	хэлбэлзэл	Фактор
1	Lactic-2	3.27	(0.80	0.00 - 4.70)	4.09
4	Glycolic-2	7.86	(0.70	0.00 - 2.20)	11.23
7	Glyoxylic—OX-2	3.84	(1.20	0.00 - 6.10)	3.20
9	Pyruvic-OX-2	3.49	(4.50	0.00 - 24.10)	0.78
12	3-OH-isobutyric-2	5.04	(2.50	0.00 - 9.00)	2.02
16	3-OH-isovaleric-2	1.64	(0.80	0.00 - 2.30)	2.05
20	Urea-2	293.2	(376.1	104.6 - 763.0)	0.78
26	Benzoic-1	1.70	(4.40	0.00 - 18.70)	0.39
32	Phosphoric-3	5.89	(6.60	0.00 - 43.00)	0.89
34	Ethylmalonic-2	1.50	(0.90	0.00 - 6.20)	1.67
37	Phenylacetic-1	6.21 *	(0.10	0.00 - 0.40)	62.10
39	Succinic-2	7.56	(32.70	6.50 - 65.80)	0.23
51	Glutaric-2	1.14	(1.90	0.00 - 4.00)	0.60
57	2-Deoxyteronic	2.53	(2.40	0.00 - 6.30)	1.05
70	2-hexenedioic-2	1.83	(1.00	0.00 - 16.40)	1.83
81	2-OH-glutaric-3	1.28	(2.30	0.60 - 5.90)	0.56
83	Phenyllactic-2	6.19 *	(0.30	0.00 - 4.90)	20.63
84	Pimelic-2	1.74	(3.00	0.00 - 9.30)	0.58
88	4-OH-benzoic-2	5.19	(3.80	0.00 - 7.80)	1.37
89	4-OH-phenylacetic	85.95	(27.10	8.60 - 73.20)	3.17
100	Aconitic-3	37.99	(64.70	15.10 - 86.10)	0.59
102	Vanillic-2	1.72	(0.90	0.00 - 0.00)	1.91
103	Homovanillic-2 (HVA)	8.48	(16.30	5.80 - 24.90)	0.52
105	Hippuric-2	4.71	(2.20	0.00 - 11.70)	2.14
106	Isocitric-4	13.54	(22.90	8.30 - 29.00)	0.59
107	Citric-4	37.48	(441.1	31.40 - 572.3)	0.08
109	Hippuric-1	83.47	(30.10	6.20 - 284.1)	2.77
115	Vanilmandelic-3 (VMA)	28.92	(46.60	11.70 - 84.60)	0.62
117	Decadienedionic-2	0.38	(0.70	0.00 - 2.30)	0.54
118	4-OH-phenyllactic-2	63.66	(1.80	0.00 - 7.00)	35.37
129	Uric-4	3.89	(2.60	0.00 - 7.20)	1.50
133	Tetracosane (C24)	51.90	(0.00	0.00 - 0.00)	#DIV/0!
134	IS-2 (tropic acid)	217.6 2	(0.00	0.00 - 0.00)	#DIV/0!

No. Сэжиглэх өвчин

37 Фенилкетонури

Зураг 3. Өвчтөн 2-ын генетик шинжилгээний үр дүн

Tyr356Ter (TAC > TAA) Сонгомол фенилкетонури



Ala403Val (GCT > GTT: Хөнгөн хэлбэрийн гиперфенилаланинеми

Хэлцэмж

Эрсдэлтэй бүлэгт хийгдсэн бодисын солилцооны төрөлхийн эмгэгүүдийг илрүүлэх судалгаагаар эдгээр өвчний тохиолдол нь Вьетнамд 1:11, Энэтхэгт 1:19, Хятадад 1:54, Японд 1:66 байсан [4, 8, 11, 19, 20], ба фенилкетонури, лейциноз, гомоцистеинури, метилмалонат ацидеми, пропионат ацидеми зэрэг өвчнүүд зонхилж байсан. Бидний судалгаагаар эрсдэл бүхий 223 өвчтөн хамрагдсанаас 2 өвчтөнд фенилкетонури оношлогдсон ба 1 өвчтөнд цитруллинэми 2-р хэлбэрийн сэжигтэй тохиолдол илэрсэн нь эрсдэлтэй бүлэгт хийгдсэн илрүүлэг шинжилгээнд фенилкетонури өвчний тохиолдол 1:112, бодисын солилцооны өвчний тохиолдол 1:72 байгааг илтгэж байна. Хэдийгээр уг судалгаанд хамрагдагсдын тоо цөөн боловч бусад улсын судалгаатай адил фенилкетонури өвчин зонхилон тохиолдож байлаа. Судалгаагаар

илэрсэн фенилкетонури өвчний тохиолдлууд нь масс спектрометр ба молекул генетикийн шинжилгээгээр оношлогдсон Монгол улсын анхны тохиолдлууд ба фенилкетонури оношлогдсон 2 тохиолдол хоёул хэдийн бие, сэтгэц, хөдөлгөөний хөгжлийн хоцрогдолтой байгаа нь бодисын солилцооны төрөлхийн эмгэгийг илрүүлэх шинжилгээнд хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдийг хамруулж байх, цаашлаад Монгол улсад нярайн бодисын солилцооны төрөлхийн эмгэгийг илрүүлэххөтөлбөрийг эрчимтэй нэвтрүүлэх, тухайн өвчнүүдэд тохирсон оношилгоо, эмчилгээ, хяналтын тусгай удирдамж гаргах шаардлага байгааг харуулж байна. Фенилкетонури ба бусад амин хүчлийн солилцооны өвчнүүдийг шинж тэмдэг илрэхээс өмнө эрт нярай үед илрүүлж, урьдчилан сэргийлэх дэглэм эмчилгээ хийх нь мэдрэл танин мэдэхүйн өөрчлөлтөөс сэргийлэх ач холбогдолтой[21].

Фенилкетонури өвчний эмнэлзүйн олон янз байдал нь тухайн өвчний молекул генетик дэх өөрчлөлтүүдтэй холбоотой бөгөөд Хүний генийн мутацийн санд фенилаланин гидроксилаз (*PAH*) ген дээр 700 гаруй мутаци бүртгэгдсэн байна. Бидний судалгаагаар оношлогдсон 2 өвчтөний *PAH* ген дээр 4 төрлийн мутаци (p.R243Q, p.Y356X, p.V399V, A403V) тодорхойлогдсон бөгөөд p.R243Q, p.Y356X, p.V399V мутациуд өмнө нь БНХАУ, БНСУ, Япон зэрэг Азийн орнуудын сонгомол хэлбэрийн фенилкетонури өвчтэй өвчтөнүүдэд тодорхойлогдсон[22-25] бол A403V мутаци нь Европчууд дунд элбэг тохиолддог ба хөнгөн хэлбэрийн гиперфенилаланинемиг нөхцөлдүүлж байсан [26, 27]. V399V мутаци нь полиморфизм хэлбэртэй харагдаж байгаа хэдий ч транскрипцын үйл явцад нөлөөлсөнөөс хэвийн бус мэдээллийн PHX бий болж өвчин үүсэхэд нөлөөлдөг болох нь өмнөх судалгаануудаар батлагдсан[28].

Өмнөх судалгаануудад Y356X мутаци нь сонгодог ба хөнгөн хэлбэрийн фенилкетонури өвчнийг [24], A403V мутаци нь хөнгөн хэлбэрийн гиперфенилаланинеми өвчнийг нөхцөлдүүлдэг [27] болох нь мэдээлэгдсэн. Бидний судалгаагаар оношлогдсон өвчтөнд Y356X, A403V хавсарсан гетерозигот мутаци илэрсэн ба уг хавсарсан генотип нь эмнэлзүйд сэтгэц хөдөлгөөний хөнгөн хэлбэрийн хоцрогдол, шээсний органик хүчлийн шинжилгээнд фенилацетат ба фениллактат хүчлийн бага зэргийн илрэл, цусны амин хүчлийн шинжилгээнд дунд зэргийн

ихсэлт зэрэг хөнгөн хэлбэрийн фенилкетонури өвчний фенотипыг нөхцөлдүүлж байсан. p.R243Q, p.V399V хавсарсан мутаци бүхий өвчтөний хувьд генотип ба фенотипын хувьд сонгомол хэлбэрийн фенилкетонури өвчнийг нөхцөлдүүлж байгаа нь өмнө тэмдэглэгдсэн гадны өвчтөнүүдийнхтэй адил байсан. Уг судалгаагаар илэрсэн фенилкетонури өвчтэй хүүхдүүд тухайн гэр бүлийнхээ анхны хүүхэд байсан ба оношийг масс спектрометр ба молекул генетикийн шинжилгээгээр баталгаажуулснаар гэр бүл төлөвлөлт хийх, дараагийн хүүхдэд тухайн бодисын солилцооны өвчний эрсдэлийг тодорхойлох зэрэг удамзүйн зөвөлгөө өгөх, пренатал оношилгоо хийх боломжтой болсон.

Дүгнэлт

1. Хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээг ашиглан бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийг илрүүлэх зорилгоор эрсдэлтэй бүлэгт хийгдсэн илрүүлэг шинжилгээнд амин хүчлийн солилцооны төрөлхийн эмгэг болох фенилкетонури өвчний тохиолдол 1:112 байгаа нь адил төстэй судалгааны үр дүнтэй харьцуулахад тохиолдлын тоо бага хэдий ч зонхилох өвчний хэлбэр нь адил байлаа.
2. Хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээгээр оношлогдсон фенилкетонури өвчний 2 тохиолдолд мутаци илрүүлэх шинжилгээ хийж оношийг баталгаажуулсан ба 4 төрлийн өвчин үүсгэгч мутаци илэрсэн нь бүгд Ази ба Европ өвчтөнүүдэд өмнө бүртгэгдсэн мутациуд байлаа.
3. Фенилкетонуритай өвчтөний эмнэл зүй ба удам зүйн хоорондын хамаарлыг харьцуулж үзэхэд өмнө бүртгэгдсэн сонгодог ба хөнгөн хэлбэрийн фенилкетонури өвчний фенотиптэй тухайн өвчтөний мутаци өөрчлөлтийн хэлбэр (генотипийн хэлбэр) нь дүйж байлаа.
4. Судалгаагаар илэрсэн фенилкетонуритай өвчтөнүүд нь масс спектрометр ба молекул генетикийн шинжилгээгээр оношийг баталгаажуулсан Монгол дахь анхны тохиолдол ба өвчтөнүүд хэдийн сэтгэц хөдөлгөөний хоцрогдолд хүрсэн байгаа нь бодисын солилцооны төрөлхийн эмгэгийг илрүүлэх нярайн илрүүлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх нь чухал байгааг харууллаа.

**Бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийг илрүүлэх,
оношлох**

**Бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийг хийн
хроматограф масс спектрометрийн аргаар илрүүлэх, оношлох
удирдамж**

**Бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийг хийн
хроматограф масс спектрометрийн аргаар илрүүлэх, оношлох
удирдамж**

Үндэслэл

Хүүхдийн эндэгдлийн шалтгаанд бодисын солилцооны төрөлхийн эмгэгүүд тодорхой байр эзэлж байдаг. Бодисын солилцооны төрөлхийн эмгэгүүдийг эрт илрүүлж, зөв оношилж, эмчилгээний зохистой удирдамж гаргах нь манай оронд тохиолдож байгаа хүүхдийн эндэгдлийг тодорхой хувиар бууруулах, эмгэгээс үүсэж болох хожуу үеийн үлдэц, хөгжлийн бэрхшээлээс сэргийлэх ач холбогдолтой. Иймээс зонхилон тохиолдох бодисын солилцооны эмгэгийг эрт илрүүлэх, нярайн эндэгдлийг бууруулах зорилгоор олон оронд нярайн скринингийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Бодисын солилцооны төрөлхийн эмгэг нь бие махбод дахь чухал үүрэг бүхий ферментийг хариуцсан ихэвчлэн нэг гений гажгаар үүсгэгддэг эмгэг. Энэ эмгэгийн үедбие махбодод бодисын солилцооны завсрын хорт бодис ихээр хуримтлагдсанаас эсвэл бие махбодод чухал хэрэгцээтэй бодисууд дутагдсанаас эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрдэг. Өвчний нийт тохиолдол улс орон бүрт харилцан адилгүй байдаг ба Азийн орнуудад хийсэн судалгаагаар нийт амьд төрөлтөнд тохиолдох тоо 1:2000-9000 байна. Эх барихын үеийн гэмтэл, төрөлхийн хөгжлийн гажиг, хромосомын эмгэг гэх мэт мэдэгдэхүйц шалтгаангүйгээр өсөлт хөгжлийн доройтол, хоцрогдол, оюунухааны хомсдол, энцефалопати, уналт, таталт, зүрхний ба бусад төрлийн булчингийн эмгэг, элэг дэлүү томролт, бодисын солилцооны хүчилшил, цусан дахь чихрийн багасалт, аммон, кетон биеийн ихсэлт гэх мэт эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн буюу өндөр эрсдэлтэй бүлэгт хийгдсэн Азийн орнуудын судалгаагаар эдгээр бүлэг өвчнүүд Энэтхэгт 1:19, Хятадад 1:54, Японд 1:66 тохиолдсон байна[2-11]. Үүнд фенилкетонури, лейциноз (MSUD), гомоцистинури гэх мэт амин хүчлийн солилцооны эмгэгүүд, метилмалонат ацидеми, пропионат ацидеми, 1-р хэлбэрийн глутарат ацидеми гэх мэт органик хүчлийн

солилцооны эмгэгүүд зонхилон тохиолдсон байна. Хөгжсөн орнуудад эдгээр эмгэгийг оролцуулаад нийт 20 гаруй нэр төрлийн органик, амин хүчлийн солилцооны эмгэгүүдийг хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээгээр шээсэн дэх органик хүчлийг тодорхойлонилрүүлж байгаа ба энэ нь нэг сорьцноос, нэг шинжилгээний аргаар бодисын солилцооны олон нэр төрлийн эмгэгийг зэрэг оношлох боломж бүхий инвазив бус арга юм.

П.Жамъян нарын судалгаагаар 223 өвчтөнд Фенилкетонури өвчний 2 тохиолдол масс спектрометрийн шинжилгээгээр оношлогдсон ба удамзүйн шинжилгээгээр батлагдсан. Энэ нь бусад орныхтой төстэй байна. [11]

Энэ удирдамж нь ЭХЭМҮТ-ийн Анагаахын удамзүйн лабораторид Хийн хроматограф масс спектрометрийн аппарат ашиглан тодорхой шинж тэмдэг бүхий өвчтөнүүдэд төрөлхийн амин хүчил, органик хүчил, өөхний хүчлийн солилцооны эмгэгүүдийг илрүүлэх зорилгоор ашиглагдана.

Шинжилгээнд хамруулах заалт

Шалтгаан тодорхойгүй, сэтгэц, хөдөлгөөний гүнзгий хоцрогдол, хордлогот энцефалопати, бодисын солилцооны хүчилшил, гипераммонеми, олон дахисан гүнзгий гипогликеми, кетоз зэрэг эмнэлзүй, лабораторийн хавсарсан өөрчлөлтөөс 3 ба түүнээс олон илэрсэн эсвэл эмнэлзүйн шинж тэмдгээр бодисын солилцооны эмгэгүүдийг сэжиглэж байгаа тохиолдолд шинжилгээнд хамруулна. Бодисын солилцооны эмгэгийн оношилгоонд дээж авах хуудсыг заавал бөглөнө (Хавсралт 2).

**Хийн хроматограф масс спектрометрийн шинжилгээ ашиглан
шээсний органик хүчлийг тодорхойлох ажиллагааны заавар**

Дагаж мөрдөх ажилтан:

Албан тушаал	Лаборант, их эмч
Хэрэглэгч	Лаборант, техникч нар
Хянаж баталгаажуулах	Лабораторийн эмч, тасгийн эрхлэгч

Эрх, Хязгаарлалт: Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Анагаах ухааны удамзүйн лабораторид мөрдөгдөнө.

